



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 15 № 3/470
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ”ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэг
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:
sambuunyamy@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг: serjmyadagb@audit.
gov.mn

АБ-ын хаяг: Ас-Арвай аудит
ХХК
Утас: 99110691, 70115359
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.as-arvai.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8дахь зүйлийн 8.9.8 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дахь зүйлийн 15.1.2 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 18 дахь зүйлийн 18.5 заалтын дагуу Монгол улсын Ерөнхий аудиторын бүрэн эрхийн хүрээнд “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/298/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Компаний тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт/СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг манай компани 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөв.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2017 оны 2 дүгээр сарын 03-нд “Ас-Арвай аудит” ХХК-нд ирүүлсэн болно.

Аудитыг 2017 оны 2 дугаар сарын 10-наас 2017 оны 03 дугаар сарын 09-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд байгууллагын удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компаний тухай хууль, Төсвийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт орсон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт орж, 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс шинээр мөрдөгдсөн.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ынбүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчний салбарын талаар дэвшүүлсэн зорилт, чиг үүрэг, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тус байгууллагын захирлын үйл ажиллагаанд өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө болон бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Захиргаа, удирдлагын хэлтэс, Санхүү эдийн засгийн хэлтэс, Зураг төсөл магадлалын хэлтэс, Захиалагч, техник хяналтын хэлтэс, Сургалт үйлдвэрлэлийн цогцолбор гэсэн 5 үндсэн нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь гадаад хамтын ажиллагаагаа Монгол улсын гадаад харилцааны нэгдсэн бодлого болон Эрчим хүчний яамны гадаад хамтын ажиллагааны бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан явуулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д“Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө.”

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны хүрээнд зорилтот түвшингээ Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраар батлуулж, мөрдөж ажиллаж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу СТОУС, Сангийн сайдын 77 дугаар тушаалд нийцэх НББ-ийнDiamond програмаар боловсруулж санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Материаллаг байдал:

Тус байгууллагын материаллаг байдлын түвшингнийт хөрөнгө буюу11,960.9 сая төгрөгийн 1.0 хувь болох 119.6 саятөгрөгөөр тооцлоо. Нийт хөрөнгө урд оноос 1,976.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотойгоор материаллаг байдлыг түвшинг тооцож авлаа. /ТАБ-СТА-А-2/. Агуулгын хувьд буюу шинж чанарын хувьд материаллаг аливаа зүйл байхгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ындотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГнь нийтдээ 3,129.1 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөнөөс 3,682.1 сая төгрөгийн орлого олсон байна. Нийт зардалд 5,071.7 сая төгрөг төсөвлөсөнөөс 3,882.7 сая төгрөг зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь 2014 оны 7 дугаар сарын 1-нд шилэн дансны хууль батлагдсантай холбоотойгоор 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс Shilendans.gov.mn сайтад өөрийн сервирийг үүсгээд мэдээлэлээ оруулж эхлээд байна.Шилэн дансны хуулинд заагдсан мэдээлэлийг хавсралтад дурдсан хугацаанд байнга оруулж байгаа.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд NISSAN PATROL автомашиныг 163,5 сая төгрөгөөр худалдан авсан нь батлагдсан төсөвт тусгагдаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дахь зүйлийн 24.2-д “төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа ажил үйлчилгээ худалдаж авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах, төсөвт батлагдсан зардлаар эд хөрөнгө худалдан авч байх зөвлөмж хүргүүлэв.

2. Захирал А.Пүрэвжавыг гадаадад томилолтоор явахад нь утасны барьцаанд 0.5 сая төгрөг шилжүүлсэн нь Нягтлан бодох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитын зөвлөмжөөр 2016 оны 12 дугаар сарын 15-нд Эрчим хүчний хөгжлийн төвийн дансанд 0.5 сая төгрөгийг тушаасан байна.

3. Эрчим хүчний яаманд төвлөрүүлсэн 384.7 сая төгрөг нь Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-д “Эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Техник хяналтын зардалд төвлөрсөн орлого болон тусгай зөвшөөрөл олголтын орлогын хураамж, дулаан, цахилгааны техникийн нөхцөл олголтын хураамжийн төвлөрсөн орлогоос Эрчим хүчний яаманд төвлөрүүлэн зарцуулахыг зогсоох.

4. Цалин болон нэмэгдэлд олгосон 20,064,847 төгрөг олгосон нь Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолыг зөрчиж, зөвхөн ажил олгогч, ажилчдын төлөөлсөн Үйлдвэрчний Эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээний дагуу олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин болон нэмэгдлийн хэмжээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулан мөрдөж ажиллах.

Анхаарал татахуйц бусад асуудлууд

Эрчим хүчний сайдын 2015 оны 36 дугаар тушаалаар баталсан журмын 2.2-д “Техник хяналтын зардалд төвлөрсөн орлогын 90 хувийг Эрчим хүчний хөгжлийн төв, үлдэх хувийг Эрчим хүчний яам төвлөрүүлж зарцуулна”, 2.3-д “Тусгай зөвшөөрөл олголтын орлогын хураамж, дулаан, цахилгааны техникийн нөхцөл олголтын

хураамжийн төвлөрсөн орлогын 70 хувийг Эрчим хүчний хөгжлийн төв, 30 хувийг Эрчим хүчний яам зарцуулна”- гэж тус тус заасан байна.

Дээрх тушаалаар Эрчим хүчний яаманд 40 хувийг төвлөрүүлэн зарцуулахаар заасан нь Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т “Эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2016 онд Эрчим хүчний хөгжлийн төвийн орлогоос 384.7 сая төгрөгийг ЭХЯ авч зарцуулсан байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд аудит хийгээд авлага 861.8 сая, мөнгөн хөрөнгө 119.7 сая, үндсэн хөрөнгө 17.0 сая, орлого 1,824.8 сая, зардал 133.6 сая төгрөг нийт 2,956.9 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна. Эдгээр зөвлөмжөөс 861.8 сая төгрөгийн авлагатай холбоотой зөвлөмж нь биелээгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийгээд 568.7 сая төгрөгний 4 зөрчил илрүүлж, 4 зөвлөмж хүргүүлэв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас хавсаргав.



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Зөвшөөрөлгүйгээр автомашин худалдаж авсан.

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд тусгасан.

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3

Эрчим хүчний яаманд төвлөрүүлсэн мөнгө нь Эрчим хүчний тухай хуулийг зөрчсөн байна.

Тэргүүлэх ач холбогдол №4 зүйлс:

Асуудал 4

Цалингийн нэмэгдэл нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна.

2017.03.15

Менежментийн захидал

Аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөдтүүнд:

- 1.Батлагдсан төсвөөр хөрөнгө худалдан авах,
- 2.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд тусгахгүй байх,
- 3.Эрчим хүчний тухай хуулийг мөрдөж ажиллах,
- 4.Цалин болон нэмэгдэлд олгосон 20,064,847(Хорин сая жаран дөрвөн мянга найман зуун дөчин долоон) төгрөгийн зөрүү байгаа нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна. Цалин болон нэмэгдлийн хэмжээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулан мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Үндсэн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>Ажиглалт</u> Тайлант хугацаанд NISSAN PATROL автомашиныг 163,5 сая төгрөгөөр худалдан авсан нь батлагдсан төсөвт тусгагдаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дахь зүйлийн 24.2-д “төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авна” гэсэн заалтыг зөрчсөн байна.	<u>Зөвлөмж</u> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.
<u>Эрсдэлүүд</u> Зардал хэтрэх.	<u>Төсвийн захирагчийн хариу</u> Батлагдсан төсвийн дагуу дээд газрын зөвшөөрлөөр хөрөнгө худалдаж авна.

Асуудал 2: Зардал	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт</u> Захирал А.Пүрэвжавыг гадаадад томилолтоор явахад нь утасны барьцаанд 0.5 сая төгрөг шилжүүлсэн нь Нягтлан бодох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.	<u>Зөвлөмж</u> Нягтлан бодох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах.
<u>Эрсдэлүүд</u> Санхүүгийн тайланд бүртгэлээр тавих хяналт сул, үнэн зөв, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.	<u>Төсвийн захирагчийн хариу</u> 2016 оны 12 дугаар сарын 15-нд 0.5 сая төгрөгийг ЭХХТ-ийн дансанд тушаасан байна.

Асуудал 3: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №3
<u>Ажиглалт</u> Эрчим хүчний яаманд төвлөрүүлсэн 384.7 сая төгрөг нь Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-д “Эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.	<u>Зөвлөмж</u> Техник хяналтын зардалд төвлөрсөн орлого болон тусгай зөвшөөрөл олголтын орлогын хураамж, дулаан, цахилгааны техникийн нөхцөл олголтын хураамжийн төвлөрсөн орлогоос Эрчим хүчний яаманд төвлөрүүлэхгүй байх.
<u>Эрсдэлүүд</u> Эрх, үүрэг зөрчигдөх	<u>Төсвийн захирагчийн хариу</u> Эрчим хүчний тухай хуулийг мөрдөж ажиллана.

Асуудал 4: Цалин	Тэргүүлэх ач холбогдол №4
<u>Ажиглалт</u> Цалин болон нэмэгдэлд олгосон 20,064,847 төгрөг олгосон нь Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолыг зөрчиж, зөвхөн ажил олгогч, ажилчдын төлөөлсөн Үйлдвэрчний Эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээний дагуу олгосон байна.	<u>Зөвлөмж</u> Цалин болон нэмэгдлийн хэмжээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулан мөрдөж ажиллах.
<u>Эрсдэлүүд</u> Цалингийн зардал хэтрэх.	<u>Төсвийн захирагчийн хариу</u> Батлагдсан төсвийг мөрдөж ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	696,448,982.55	1,744,231,349.85
1.1.2	Дансны авлага	2,063,182,073.51	1,833,783,554.91
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	28,007.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	615,049,459.56	569,261,354.40
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	474,000,240.40	534,763,051.50
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бvlлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,848,680,756.02	4,682,067,317.66
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,124,920,452.83	7,219,720,318.63
1.2.2	Биет бус хөрөнгө	10,958,564.99	59,116,660.59
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,135,879,017.82	7,278,836,979.22
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,984,559,773.84	11,960,904,296.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	24,239,010.00	71,799,363.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	1,912,609.48	938,515.99
2.1.1.4	НДШ-ийн өглөг	405,000.00	217,463.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,340,340,309.00	2,580,331,453.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,366,896,928.48	2,653,286,794.99
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,098,007,068.48	6,384,396,934.99
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	2,637,320,333.16	2,637,320,333.16
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,075,302,847.21	1,075,302,847.21
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	102,518,428.41	993,388,457.48
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,071,411,096.58	870,495,724.04
2.3.20	Эздийн өмчийн дүн	4,886,552,705.36	5,576,507,361.89
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	9,984,559,773.84	11,960,904,296.88

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2016.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,531,975,096.82	3,351,022,981.98
2	Борлуулалтын өртөг	30,890,702.31	28,965,286.79
3	Нийт ашиг (алдагдал)	2,501,084,394.51	3,322,057,695.19
4	Түрээсийн орлого	58,109,151.78	58,435,180.33
5	Хүүгийн орлого	28,637,211.14	42,946,810.50
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Улсын төсвийн санхүүжилт	0.00	0.00
8	Бусад орлого	131,806,326.59	87,181,007.48
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,087,490,407.61	3,770,159,068.82
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	576,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,268,528.23	137,058,722.40
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-3,024,622.96	-74,255,302.85
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-366,609,418.32	-197,310,955.77
19	Орлогын татварын зардал	2,863,721.11	3,604,416.77
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-369,473,139.43	-200,915,372.54
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-369,473,139.43	-200,915,372.54
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	-369,473,139.43	-200,915,372.54
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016.12.31

	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Галаад валютын хөрвүүлэлтийн нооц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,637,320,333.16	0.00	0.00	1,075,302,847.21	0.00	102,518,428.41	1,455,915,970.01	5,271,057,578.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-15,031,734.00	-15,031,734.00
3	Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	0.00	0.00	1,075,302,847.21	0.00	102,518,428.41	1,440,884,236.01	5,256,025,844.79
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-369,473,139.43	-369,473,139.43
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,637,320,333.16	0.00	0.00	1,075,302,847.21	0.00	102,518,428.41	1,071,411,096.58	4,886,552,705.36
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	0.00	0.00	1,075,302,847.21	0.00	102,518,428.41	1,071,411,096.58	4,886,552,705.36
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	4,983,818.00	0.00	4,983,818.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-200,915,372.54	-200,915,372.54
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,637,320,333.16	0.00	0.00	1,075,302,847.21	0.00	993,388,457.48	870,495,724.04	5,576,507,361.89

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,022,634,448.05	3,626,195,382.59
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ	2,713,536,603.79	3,520,611,198.57
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж,	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан	4,561,321.00	8,491,943.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	192,512.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	304,344,011.26	97,092,241.02
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-3,097,808,648.93	-3,566,502,529.19
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-1,694,205,514.93	-1,891,956,338.14
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад	-288,557,102.00	-356,327,094.00
1.2.3	Бараа материал худалдан авахад	-183,338,770.70	-341,198,599.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-52,601,091.89	-62,351,691.72
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс,	-67,236,554.00	-65,521,439.86
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-9,130,682.00	-1,090,476.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-179,223,162.68	-195,484,110.56
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-23,591,446.00	-27,076,253.80
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-599,924,324.73	-625,496,526.11
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр	-75,174,200.88	59,692,853.40
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	28,637,211.14	42,946,810.50
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	28,637,211.14	42,946,810.50
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-76,673,980.00	-577,938,802.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд	-76,673,980.00	-577,938,802.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны	-48,036,768.86	-534,991,991.50
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	86,558,558.12	1,528,553,820.04
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас	80,697,797.45	1,386,022,783.00

3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	5,860,800.67	142,531,037.04
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-1,592,272.44	-5,472,314.64
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн	-1,592,272.44	-5,472,314.64
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр	84,966,325.68	1,523,081,505.40
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-38,244,644.06	1,047,782,367.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн	734,693,626.61	696,448,982.55
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн	696,448,982.55	1,744,231,349.85